*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 717,479.9 мянган төгрөг нь орон нутгийн Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 278,380.1 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 282,433.0 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 156,66.7 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 269,479.5 мянган төгрөг болж өмнөх оноос 20,271.8 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 2. Авлагын үлдэгдэл*

*/ мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Татаас санхүүжилтийн авлага | - | 37,220.3 | 37,220.3 |
| Байгууллагаас авах авлага | 86,224.0 | 56,999.5 | (29,224.5) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 131,000.0 | 129,000.0 | (2,000.0) |
| Хувь хүмүүст олгосон зээл | 72,527.3 | 46,259.6 | (26,267.7) |

| | | | |
|---|---|---|---|
| **Дүн** | 289,751.3 | 269,479.5 | -20,271.8 |

Эх сурвалж: *Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 13.8 хувь буюу 37,220.3 мянган төгрөг нь тус сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн авлага, 17.2 хувь буюу 46,259.6 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн иргэдэд олгосон зээлийн авлага, үлдсэн 69 хувь буюу 185,999.5 мянган төгрөг нь ОНХС-ийн авлагын үлдэгдэл бөгөөд үүнээс 129,000.0 мянга нь 2011 оноос олгосон малжуулах зээлийн авлага, 56,999.5 мянган төгрөг нь байгууллагаас авах авлага байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 26,543.1 | 37,220.3 | 10,677.2 | 13.8 |
| ИТХ | 3,001.4 | 0.0 | -3,001.4 | 0.0 |
| СХС | 72,527.3 | 46,259.6 | -26,267.7 | 17.2 |
| ОНХСан | 187,679.5 | 185,999.5 | -1,680.0 | 69.0 |
| **НИЙТ ДҮН** | **289,751.3** | **269,479.5** | **-20,271.8** | **100.00** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд ИТХ-ын авлага бүрэн барагдаж, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 36.2 хувиар, ОНХС-ийн авлага 0.9 хувиар буурсан бол ЗДТГ-ын авлага 40.2 хувиар өссөн байна.

### 3.5.3 Бараа материал

Тайлант оны бараа материал дансны эцсийн үлдэгдэл 161,941.9 мянган төгрөг болж өмнөх оноос 24,031.7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 4. Бараа материалын үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 19,302.7 | 24,240.7 | 4,938.0 |
| Эм боох материал | 2,262.0 | 2,341.8 | 79.8 |
| Бичиг хэргийн материал | 2,291.9 | 2,165.9 | -126.0 |
| Аж ахуйн материал | 44,068.8 | 81,174.3 | 37,105.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 284.0 | 0.0 | -284.0 |
| Барилгын засварын материал | 0.0 | 2,382.0 | 2,382.0 |
| Бусад хангамжийн материал | 64,023.0 | 49,637.1 | -14,385.9 |
| Мал амьтад | 5,677.8 | 0.0 | -5,677.8 |
| **Дүн** | **137,910.2** | **161,941.9** | **24,031.7** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 161,941.9 мянган төгрөг болж 24,031.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЗДТГ-т 41,497.5 мянган төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авч, 5,677.7 мянган төгрөгийн мал амьтан хорогдсоныг данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлжээ.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 3,472.9 | 4,989.0 | 1,516.1 | 3.1 |
| ЗДТГ | 134,437.3 | 156,952.9 | 22,515.6 | 96.9 |
| **НИЙТ ДҮН** | **137,910.2** | **161,941.9** | **24,031.7** | **100.0** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 432,064.1 мянган төгрөгийн бараа материалаас 245,398.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 186,665.5 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн нийт хасагдсан 408,032.4 мянган төгрөгийн бараа материалаас 254,196.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл*

*/мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | 432,064.1 | Хасагдсан | 408,032.4 |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 245,398.6 | Худалдсан, зарцуулсан | 254,196.7 |
| Хандиваар | 186,665.5 | шилжүүлсэн | 49,528.4 |
| бусад | 0.0 | бусад | 104,307.3 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 4,075,934.0 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 466,846.9 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 3,609,087.1 | 4,075,934.0 | 466,846.9 | 99.2 |
| Барилга байгууламж, орон сууц | 2,409,858.1 | 2,449,120.3 | 39,262.3 | 59.6 |
| Тээврийн хэрэгсэл | 233,674.4 | 452,527.4 | 218,853.0 | 11.0 |
| Машин тоног төхөөрөмж | 315,508.6 | 310,823.8 | -4,684.8 | 7.6 |
| Тавилга эд хогшил | 122,095.6 | 128,488.9 | 6,393.4 | 3.1 |
| Номын фонд | 1,254.5 | 1,254.5 | 0.0 | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 526,696.0 | 733,719.0 | 207,023.0 | 17.9 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 31,050.0 | 31,050.0 | 0.0 | 0.8 |
| Программ хангамж | 2,950.0 | 2,950.0 | 0.0 | 0.1 |
| Бусад биет бус хөрөнгө | 28,100.0 | 28,100.0 | 0.0 | 0.7 |
| **НИЙТ ДҮН** | 3,640,137.1 | 4,106,984.0 | 466,846.9 | 100.0 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 98.9 хувийг Засаг даргын тамгын газар, 1.1 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 29,230.1 | 43,606.1 | 14,376.0 | 1.1 |
| ЗДТГ | 3,610,907.0 | 4,063,377.9 | 452,470.9 | 98.9 |
| **НИЙТ ДҮН** | **3,640,137.1** | **4,106,984.0** | **466,846.9** | **100.0** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө данс 623,498.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр тус сумын ЗДТГ 19,119.7 мянга, ИТХ 10,999.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, хандив тусламжаар ЗДТГ 590,002.3 мянга, ИТХ 3,377.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Харин 156,651.2 мянган төгрөгөөр хасагдсан нь тус сумын ЗДТГ-ын нийт акталсан хөрөнгө эзэлж байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл* */мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | **623,498.1** | Хасагдсан | **156,651.27** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 30,118.8 | Худалдсан | 0 |
| Хандиваар | 593,379.4 | Акталсан | 156,651.27 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,578.1 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 38,856.5 мянган төгрөг болж 35,278.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 3,578.1 | 38,856.5 | 35,278.4 | 100.0 |
| Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 0.0 | 37,220.3 | 37,220.3 | 95.8 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 831.1 | 831.1 | 2.1 |
| Байгууллагад төлөх өглөг | 3,578.1 | 805.0 | (2,773.1) | 2.1 |
| **Дүн** | 3,578.1 | 38,856.5 | 35,278.4 | 100.0 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 38,856.5 мянга болж эхний үлдэгдлээс 1085.9 хувиар өссөн нь тус сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн хөрөнгийг өглөгөөр тусгасантай холбоотой байна.

*Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Орон нутгийн ерөнхий орлого | - | 37,220.3 | 37,220.3 | 95.8 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ЗДТГ | - | 831.2 | 831.2 | 2.1 |
| ОНХС | 3,578.1 | 805.0 | (2,773.1) | 2.1 |
| ДҮН | 3,578.1 | 38,856.5 | 35,278.4 | 100.0 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,666,193.7 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 4,082,541.3 мянган төгрөг болж, 416,347.6 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 235,921.6 | 235,921.6 | - | 5.8 |
| **Хуримтлагдсан үр дүн** | 3,413,472.6 | 3,830,617.9 | 417,145.3 | 93.8 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 16,799.5 | 16,001.8 | (797.7) | 0.4 |
| **Дүн** | 3,666,193.7 | 4,082,541.3 | 416,347.6 | 100.0 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 416,347.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар 17/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 340,930.0 мянга, хүү торгуулийн орлогыг 7,500.0 мянга,төсөвт байгууллагын өөрийн орлогыг 10,000.0 мянган төгрөг нийт 348,430.0 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/12 дугаар тогтоолоо 74,500.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого*

*/мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **1.Татварын орлого** | **405,430.0** | **470,266.0** | **64,836.0** | **116.0** |
| ЦХТА орлого /суутган/ | 218,000.0 | 264,000.5 | 46,000.5 | 121.1 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 1,200.0 | 1,408.4 | 208.4 | 117.4 |
| Бууны татвар | 4,830.0 | 7,291.9 | 2,461.9 | 151.0 |
| ИОТХ | 79,500.0 | 108,872.5 | 29,372.5 | 136.9 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1,000.0 | 898.1 | (101.9) | 89.8 |
| Хадгаламжийн хүүгийн орлого | 36,600.0 | 38,599.2 | 1,999.2 | 105.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого | 2,000.0 | 860.0 | (1,140.0) | 43.0 |
| Малд ногдуулах албан татвар | 40,000.0 | 26,675.7 | (13,324.3) | 66.7 |
| Газрын төлбөр | 12,800.0 | 8,462.7 | (4,337.3) | 66.1 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 9,000.0 | 12,847.0 | 3,847.0 | 142.7 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | - | 150.0 | 150.0 | |
| ТТАМАТөлбөр | 500.0 | 200.0 | (300.0) | 40.0 |
| **2.Татварын бус орлого** | **17,500.0** | **30,219.6** | **12,719.6** | **247.4** |
| Хүү торгуулийн орлого | 7,500.0 | 18,557.0 | 11,057.0 | 247.4 |
| Газрын дуудлага худалдааны орлого | - | 1,643.0 | 1,643.0 | |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 10,000.0 | 10,019.6 | 19.6 | 100.2 |
| **Нийт дүн** | **422,930.0** | **500,485.6** | **77,555.6** | **118.3** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 116 хувь буюу 64,836.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Үүнээс цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 46,000.0 мянга, ИОТХ 29,372.5 мянга, бууны албан татвар 2,461.9 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 1,999.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1,000.0 мянган төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөснөөс 10,019.6 мянган төгрөгийн орлого төвлөрч 2 хувиар давуулан биелсэн байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,317,506.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 1,745,811.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж тайлант оны төсвийн гүйцэтгэлийн зардлын дүн 75.3 хувь байна.

*Хүснэгт №14.Төсвийн гүйцэтгэл (Хөтөлбөр, үр дүнгээр)*

*/мянган төгрөг/*

| № | ТЕЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт | | Хөтөлбөрийн хүрэх үр дүн | Хөтөлбөрийн биелэлт | Хөтөлбөрт зарцуулах төсөв | Хөтөлбөрт зарцуулсан төсөв |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1 | 70105 | Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулж ИТХ-ын хуралдааныг зохион байгуулах, хуралдах нөхцөл боломжийг хангах, Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулах , ИТХ-ын зөвлөлийн хурлыг улиралд 1-с доошгүй удаа хуралдуулж шийдвэр гаргах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, гарсан шийдвэрийг ил тод нээлттэй байдлыг ард иргэдийг мэдээ, | 2024 онд Баянхонгор сумын ИТХ-ын хуралдаанаас баталсан 197203,5 мянган төгрөгийн санхүүжилтээр үндсэн үйл ажиллагаа явуулсан.Сумын ИТХ-ын зөвлөл 4 удаа хуралдсан. ИТХ-ын төлөөлөгчдийн хурал 6 удаа зохион байгуулагдсан байна. Хурлаас гарсан аливаа шийдвэрийг иргэдэд нээлттэй ил тод мэдээлэн ажилласан. | 188,203.5 | 176,963.9 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллээр хангаж ИТХ-ын ажлын албыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах | | | |
| 1.2 | | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, албан байгууллагыг татан оролцуулах замаар хамтран ажиллах, Хүүхэд залуучууд, иргэдэд хандсан сургалтуудыг зөв оновчтой хэлбэрээр зохион байгуулах | Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж үр дүнг тооцон ажилласан. 2024 онд Гурванбулаг сумын ГХУСАЗСЗ нь сумын ИТХ-ын хуралдаанаас баталсан 9000 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, тайлант хугацаанд төлөвлөсөн 3 бүлэг 12 ажлаас 10 ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна. | 9,000.0 | 9,000.0 |
| 2 | 70106 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | Засаг даргын харьяа төсвийн байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангаж ИТХ-ын хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 25 орон тоотойгоор 2,083303,0 төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаа явуулсан. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд мэдээллийн цаг арга хэмжээ зохион байгууллаа. Мэдээллийн цаг арга хэмжээг 14 хоног бүр төрийн байгууллагууд салбарынхаа хууль, тогтоомж, дүрэм журам, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэж ажиллалаа. Үүнд 3 байгууллага хуваарийн дагуу хамрагдаж 230 гаруй иргэд төрийн албан хаагчдад 10 сэдвээр сургалт мэдээллийг зохион байгууллаа. Мөн хуультай уялдуулан хувь хүний хөгжлийн сургалтыг 10 удаа давхардсан тоогоор 500 гаруй иргэдэд сургалт мэдээллийг зохион байгуулсан. Сумын иргэний танхимыг бүрэн тохижуулж ашиглалтад оруулснаар иргэдэд сургалт, мэдээлэл зохион байгуулах таатай орчин нөхцөл бүрдсэн.Энэ онд давхардсан тоогоор онлайн сургалт семинарт 200 албан хаагч, танхимын сургалт семинарт 24 албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. | 1,150,962.5 | 1,035,245.2 |
| 3 | 70503 | Орон нутгийн зорилтод хөрөнгө оруулалт | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 19 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 9 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж нийт 13 ажил арга хэмжээ хэрэгжсэн байна. | 518,408.0 | 224,752.9 |
| 4 | 72101 | Хоршоо дэмжих сангийн хөрөнгө оруулалт | Хоршоо хөгжүүлэх сангаас ЖДҮ эрихлэгчдэд зээл олгох бодлогоор хангах | Тайланд онд ХХС-аас иргэд болон хоршоонд зээл олгоогүй. Шаардлага хангасан хоршоо төсөл ирүүлээгүй. Программ хангамжийн үнэ 150.0 мянган төгрөгийн зарцуулалт, бараа үйлчилгээний бусад зардалд 860.0 мянган төгрөг зарцуулсан байна. | 145,409.0 | 1,010.0 |
| 5 | 71801 | Сургуулийн өмнөх боловсрол | Байгууллагын тогтвортой хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах гэрэл цахилгаан түлш халаалт,цэвэр бохир усны болон урсгал засварын зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх, төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Төрийн үйлчилгээг хэвийн явуулахад шаардагдах байр ашиглалтыг зардлыг бүрэн санхүүжүүлэн өр авлагагүй ажилласан байна. Гэрэл цахилгаанд- 31181,1 Түлш халаалт- 34064,8 Цэвэр бохир ус- 534 Урсгал засварт- 4500 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна | 44,264.8 | 42,217.6 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 71802 | Ерөнхий боловсрол | Байгууллагын тогтвортой хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах гэрэл цахилгаан түлш халаалт,цэвэр бохир усны болон урсгал засварын зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх, төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Төрийн үйлчилгээг хэвийн явуулахад шаардагдах байр ашиглалтыг зардлыг бүрэн санхүүжүүлэн өр авлагагүй ажилласан байна. Гэрэл цахилгаанд- 8186,4 Түлш халаалт- 151678,7 Цэвэр бохир ус- 2431,3 Урсгал засварт- 3000 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна | 166,846.0 | 165,296.6 |
| 7 | 71602 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | Байгууллагын тогтвортой хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах гэрэл цахилгаан түлш халаалт,цэвэр бохир усны болон урсгал засварын зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх, төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахын тулд тогтмол зардлын төсвийн хуваарийг Сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн А/97 захирамжаар баталсан. Төсөвт байгууллагуудын төсвийг хуваарийн дагуу санхүүжүүлж ажиллалаа. Гэрэл цахилгаанд- 4533,7 Түлш халаалт- 33410,8 Цэвэр бохир ус- 230Урсгал засварт- 1495 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна | 41,111.3 | 39,670.6 |
| 8 | 71702 | Соёл | Байгууллагын тогтвортой хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны төлбөр болон урсгал засварын зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх төрийн үйлчилгээг хэвийн явуулах | Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахын тулд тогтмол зардлын төсвийн хуваарийг Сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 30 А/97 тоот захирамжаар батлуулан мөрдөж ажилласан байна. Тайлант жилд 100 хувь санхүүжүүлэн ажилласан. Гэрэл цахилгаанд- 1759,4 Түлш халаалт-147530,6 Цэвэр бохир ус- 365 Урсгал засварт- 2000 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна | 53,301.4 | 51,655.0 |
| **Нийт** | | | | | **2,317,506.5** | **1,745,811.8** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

## 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 17/03 дугаар тогтоолоор нийт 2,213,171.6 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/12 дугаар тогтоолоор 104,334.9 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар*

*/мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 179,091.3 | 193,055.70 | -13,964.4 |
| Засаг даргын Тамгын газар | 759,658.9 | 1,078,298.70 | -318,639.8 |
| Сургууль | | 159,846.00 | -159,846.0 |
| Цэцэрлэг | 463,515.8 | 44,264.80 | 419,251.0 |
| Эрүүл мэндийн төв | 50,652.0 | 41,111.30 | 9,540.7 |
| Соёлын төв | 59,237.7 | 53,301.40 | 5,936.3 |
| Сум хөгжүүлэх сан | | 137,900.00 | -137,900.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 505,393.70 | -505,393.7 |
| **Нийт дүн** | 1,512,155.7 | 2,213,171.6 | -701,015.9 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 17/03 дугаар тогтоолоор анх 2,213,171.6 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/12 дугаар тогтоолоор 104,334.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,317,506.5 мянган төгрөг баталжээ.

Нийт зардлын 349,560.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 929,680.5 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 412,930.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 10,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 14,000.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогоос, 601,335.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн болон санхүүгийн дэмжлэгээс авах санхүүжилтээс 1,849,897.8 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 42,176.6 мянга, нийт 1,892,074.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 133,669.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар* */мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН |
|---|---|---|---|---|---|
| ЗДТГ | 1,150,962.50 | 1,035,245.17 | 115,717.33 | 89.9 | 115,736.9 |
| ИТХ | 197,203.50 | 185,963.97 | 11,239.53 | 94.3 | 11,249.0 |
| Соёлын төв | 53,301.40 | 51,655.02 | 1,646.38 | 96.9 | 1,646.4 |
| Сум хөгжүүлэх сан | 145,409.00 | 1,010.00 | 144,399.00 | 0.7 | - |
| Сургууль | 166,846.00 | 165,296.56 | 1,549.44 | 99.1 | 1,549.4 |
| Цэцэрлэг | 44,264.80 | 42,217.61 | 2,047.19 | 95.4 | 2,047.2 |
| ЭМТ | 41,111.30 | 39,670.57 | 1,440.73 | 96.5 | 1,440.7 |
| ОНХС | 518,408.00 | 224,752.88 | 293,655.12 | 43.4 | - |
| **Нийт дүн** | **2,317,506.50** | **1,745,811.77** | **571,694.73** | **75.3** | **133,669.6** |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,745,811.7 мянган төгрөг буюу 75.3 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 115,717.3 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 11,239.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 293,655.1 мянга, хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүйтэй холбоотой 144,399.0 мянга, соёлын төвийн тогтмол зардлыг 1,646.4 мянга, ЕБС-ийн тогтмол зардлыг 1,549.4 мянга, цэцэрлэг 2,047.2 мянга, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг 1,440.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 2,064,583.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 114,273.2 мянган төгрөг нийт 2,178,956.5 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 2,039,770.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 54,645.0 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 47,320.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, ЗДТГ-ын нэмэлт санхүүжилт дансны үлдэгдэл 37,220.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | НИЙТ |
|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 2,001,360.0 | 177,596.5 | 2,178,956.5 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,001,360.0 | 63,223.2 | 2,064,583.2 |
| Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 114,373.2 | 114,373.2 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | 2,001,360.0 | 140,376.1 | 2,141,736.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 54,645.0 | 54,645.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,001,360.0 | 38,410.7 | 2,039,770.7 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 47,320.5 | 47,320.5 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | 0.0 | 37,220.3 | 37,220.3 |

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугээр сарын 28-ний өдрийн 1/59 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Гурванбулаг сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Б.Мөнхдалай, 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны дарга Б.Туулцэцэг нар зурж байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт батлагдсан төсвийн 2,317,506.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,175.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 15,063.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

**4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш орлогын 491,634.3 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 153,628.5 мянган төгрөгийн 7 гүйлгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаанд нь мэдээлсэн байна.

**4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Гурванбулаг сумын Засаг

даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэсэн ба төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан байна.

### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 48,601.4 мянган төгрөгөөр баталж 45,729.8 мянган төгрөгийг зарцуулж 2,871.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гурванбулаг сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 83 арга хэмжээ төлөвлөж 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 85.18 хувьтай дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 83 арга хэмжээнд зориулан нийт 2,317,506.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,745,811.7 мянган төгрөгийг зарцуулж 75.3 хувийн биелэлттэй байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Гурванбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Гурванбулаг сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | | | | 1 | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | | **3** | | **1** | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 248,129.8 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 194,405.9 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 53,723.9 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

*Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг даргын тамгын газар | | | | | |
| 1 | Засгийн газрын 2024 оны 63-р тогтоолоор ОБЕГ-аас тус байгууллагад үнэ төлбөргүй ирсэн 187,000,000 төгрөгийн үнэ бүхий Toyota Hilux автомашиныг үндсэн хөрөнгийн дансанд орлогод хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна. | 187,000.00 | Санхүүгийн тайланд залруулсан. | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Р.Гантулга, Б.Дэлгэрдалай |
| Орон нутгийн хөгжлийн сан | | | | | |
| 1 | 2023 онд сангийн хөрөнгөөр Цаг уурын станцын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах ажлыг “Нью бест хаус” ХХК гэрээ байгуулж урьдчилгаа төлбөрт 53,723.916 төгрөгийг олгосон. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон боловч одоо хүртэл төлбөрийн актыг барагдаагүй, төсөв захирагч нь ажлаас чөлөөлөгдсөн байна. | 53,723.90 | Зөвлөмж | Засаг дарга, нягтлан бодогч | Б.Мөнхдалай, Б.Няммэйший |
| 2 | Малын эзэмгжүүлэлтийн эргэн төлөлтийн орлого дутуу бүртгэсэн байна. | 7,405.90 | Санхүүгийн тайланд залруулсан. | Засаг дарга, нягтлан бодогч | Б.Мөнхдалай, Б.Няммэйший |
| | **Нийт дүн** | **240,723.90** | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,203.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Тайлант онд улсын тэмдэгтийн хураамж 101.9 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,140.0 мянга, малд ногдуулах албан татвар 13,324.3 мянга, газрын төлбөр 4,337.3 мянга, ТТАМАТ 300.0 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.1 дэх “Жинхэнэ хэрэгжилтийн”, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төсвийн орлого, зарлагыг төлөвлөлийн үндэслэлтэй төлөвлөж зарцуулах зөвлөмж хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд улсын тэмдэгтийн хураамж 101.9 мянга, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого 1,140.0 мянга, малд ногдуулах албан татвар 13,324.3 мянга, газрын төлбөр 4,337.3 мянга, ТТАМАТ 300.0 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөө тасарсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1, 5.1.1, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого , MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. | 1 | 19,203.5 | | | | | 1 | 19,203.5 |
| **Дүн** | **1** | **19,203.5** | | | | | **1** | **19,203.5** |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----------oOo-----------